

## ГАРЧИГ

<b>НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....</b>	<b>2</b>
1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл .....	2
1.2 Төсөл хэрэгжих талбайн байршил .....	2
<b>ХОЁР. ТӨСЛИЙН ХУЧИН ЧАДАЛ .....</b>	<b>3</b>
<b>ГУРАВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГУЙ НӨЛӨӨЛӨЛ .....</b>	<b>4</b>
3.1 Төслийн гол болзошгүй нөлөөлөл .....	4
3.2 Болзошгүй болон гол сөрөг нөлөөллийн үнэлгээний дүгнэлт .....	5
3.3 Сөрөг нөлөөллийг багасгах, арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж .....	6
<b>ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ .....</b>	<b>8</b>
4.1 Зорилго .....	8
4.2 Зорилт .....	8
4.3 Хамрах хүрээ: .....	8
4.4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	9
4.5 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ .....	10
4.6 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ .....	10
4.7 Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ .....	10
4.8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ .....	10
4.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөө .....	13
<i>Хавсралт материалын жагсаалт .....</i>	<i>14</i>
<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b>	
Хүснэгт 1 Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа .....	4
Хүснэгт 2 Төслийн гол сөрөг нөлөөлөл .....	5
Хүснэгт 3 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ .....	6
Хүснэгт 4 2024 оны төлөвлөсөн БОМТ-ний нэгтгэл мөнгөн дүн .....	8
Хүснэгт 5 Сөрөг нөлөөлөл бууруулах арга хэмжээ .....	9
Хүснэгт 6 Нөхөн сэргээлтийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ .....	10
Хүснэгт 7 Осол эрсдэлийн менежмент .....	11
Хүснэгт 8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	12
Хүснэгт 9 Удирдлага зохион байгуулалт ба осол эрсдэлийн төлөвлөгөө .....	12
Хүснэгт 10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	13
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b>	
Зураг 1 Төслийн талбайн байршил .....	2
Зураг 2 Төслийн талбайн өнөөгийн нөхцөл байдал .....	3

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төслийн нэр:	"Ургамал хамгааллын бодис импортлох, хадгалах, худалдаалах"
Төсөл хэрэгжүүлэгч:	"Өгөөж оргил" ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	1311012137
Регистрийн дугаар:	3751376
Хаяг, байршил:	Сэлэнгэ аймаг, Ерөө сум, 2 дугаар баг
Утас:	99351919, 99060015
Ашиглах талбай:	480м <sup>2</sup>

### 1.2 Төсөл хэрэгжих талбайн байршил

Төсөл хэрэгжүүлэгч нь 5 нэр төрлийн химийн бодисыг импортлох, хадгалах, худалдаалах үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн бөгөөд химийн бодис хадгалах агуулахын байршил нь Сэлэнгэ аймаг, Ерөө сум, 2 дугаар багийн нутаг дэвсгэрт нийт хэмжээ 480 м<sup>2</sup> талбай бүхий агуулах түрээсэлдэг байна.

Хүснэгт 1. Нэгж талбарын солбицлын цэг

№	х	у	Урт
1	617298.17	5509557.22	130.27
2	617415.31	5509614.56	61.31
3	617442.87	5509559.84	120.72
4	617336.64	5509502.22	22.47
5	617325.87	5509521.93	8.17
6	617318.68	5509518.03	44.26

Хүснэгт 2. Барилгын талбайн солбицлын цэг

№	х	у	Урт
Б:01.1	617326.35	5509527.8	10.78
Б:01.2	617321.39	5509537.4	7.49
Б:01.3	617328.02	5509540.9	10.78
Б:01.4	617332.98	5509531.4	7.49



Төслийн талбайн байршил



#### Таних тэмдэг

- ★ Төслийн талбайн эргэлтийн цэг
- Төслийн талбайн хил

Зураг 1 Төслийн талбайн байршил

Төслийн талбай нь Шинэстэй буудай ХХК-ийн эзэмшил бөгөөд тус компанийн агуулахыг түрээслэн үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөсөн. Талбайн ойр орчимд агуулах болон үйлдвэрийн зориулалт бүхий газрууд байдаг. Төслийн талбай нь 24 цагийн харуул хамгаалалттай.

## ХОЁР. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Ургамал хамгаалах 5 нэрийн бодис импортлон борлуулахаар төсөвлөсөн. Нийт 3 ажилтан ажиллана. 5 нэрийн 120 тн хүртэл хэмжээгээр жилд нийлүүлэхээр төлөвлөсөн. Ургамал хамгаалах бодис хадгалах агуулах нь 480м<sup>2</sup> талбайтай.

Д/д	Бодисын нэрс	Х/нэгж	CAS дугаар	Зориулалт	Химийн нэршил буюу Орц найрлага	Химийн томъёо	Хэмжээ, тн
1	Пума супер	л	71283-80-2	Үр тарианы хог ургамлын эсрэг	Феноксапроп-П-Этил	C <sub>18</sub> H <sub>16</sub> ClNO <sub>5</sub>	20
2	Клосо про	л	-	Үр тарианы хог ургамал устгах	Метсульфурон-метил	C <sub>14</sub> H <sub>15</sub> N <sub>5</sub> O <sub>6</sub> S	10
3	Раунд-ап	л	1071-83-6	Ургалтын үеийн арчилгаа	Глифосат буюу N-(фосфонотетил)-глицин	C <sub>3</sub> H <sub>8</sub> NO <sub>5</sub> P	60
4	Фаскорд		67375-30-8	Бэлчээр, ой, таримлын болон агуулахын хөнөөлт шавьжийн эсрэг	Альфа-циперметрин 100 г/л	C <sub>22</sub> H <sub>19</sub> Cl <sub>2</sub> NO <sub>3</sub>	20
5	Зингер	л	-	үндэсний илжрэл, үрийн хөгц, септориоз зэрэг өвчний эсрэг	Тэбуконазол	C <sub>16</sub> H <sub>22</sub> ClN <sub>3</sub> Oa	10



Зураг 2 Төслийн талбайн өнөөгийн нөхцөл байдал

## ГУРАВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

### 3.1 Төслийн гол болзошгүй нөлөөлөл

Төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээнээс харахад байгаль орчинд төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх гол сөрөг нөлөөллийг тодорхойлбол:

- Химийн бодисыг тээвэрлэх явцад алдаа гаргаж асгах, хөрсөнд алдах, бодисуудын битүүмжлэл алдагдах, бодисууд хоорондоо холилдох, үүнээс үүдэлтэй бодисын ууршилт үүсэх, агаар орчин болон хөрсөн бүрхэвч химийн бодисоор бохирдох.
- Бодисоор бохирдсон хаягдлыг ил задгай хаясан тохиолдолд гадаргын ус болон хөрс, ургамал бохирдох
- Хийн хаягдал (машин техникээс гарах хий, бодисын ууршилт явагдах үед гарах хий) агаар орчныг бохирдуулах

Байгаль орчны бүрдэл хэсгүүдээс нөлөөлөлд өртөх гол бүрдэл хэсэг нь хөрс, ургамал, агаар байхаар байна. Иймд төслийн зөвлөмжид дурдсан болон хууль эрхзүйн баримт бичгийг байнга мөрдөн ажиллах хэрэгтэй.

Төслийн гол сөрөг нөлөөллийг химийн бодис импортлохоос эхлэн худалдан борлуулах хүртэлх бүхийл үе шатанд авч үзэв. Үүнд богино хугацааных боловч нөхөн сэргээх хугацаа шаардах нөлөөллүүд, тэдгээрийн эрчим, хамрах хүрээ, хугацаа нь үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтын арга, хэрэглэж байгаа тоног төхөөрөмжийн сонголт зэрэгтэй ихээхэн хамааралтай байна. Төслийн үйл ажиллагааны явц дахь нөлөөлөл нь үйл ажиллагаа эрхлэгчдийн ажлын туршлага, дүрэм журмын хэрэгжилт зэргээс ихээхэн хамаарна.

*Хүснэгт 1 Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа*

№	Төслийн гол сөрөг нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Хугацаа
1.	Ургамал хамгаалах бодисын хаягдал, хог хаягдлын угаагдал хөрсөнд шингэх	Орчны хөрс, ургамал, гүний ус	Агуулахын нөлөөллийн бүсэд	Боломж бага	Намар, зуны улиралд
2.	Ургамал хамгаалах бодисыг буруу хадгалалт	Агаар, ус, хөрс, хүн	Агуулахын ойр орчим	Их	Төслийн хэрэгжих хугацаанд
3.	Ургамал хамгаалах бодисын тээвэр	Агаар, хөрс, хүн	Төслийн хэмжээнд	Дунд	Төслийн хэрэгжих хугацаанд
4.	Ургамал хамгаалах бодисын хэрэглээ	Агаар, ус, хөрс, хүн	Төслийн хэмжээнд, хэрэглэгч	Дунд	Тогтоох боломжгүй

Эндээс үзэхэд тус төсөл хэрэгжүүлэгч хамгаалалтыг сайжруулах, авто хэрэгслийг зөвхөн тогтоосон замаар явуулах шаардлагатай. Анхаарал болгоомжгүй байснаас хөрсний өнгөн хэсгийг дагтаршуулах, талхлах, ургамлын нөмрөгийг талхагдалд оруулах улмаар ургамлын төрөл, зүйл хомсдох нөхцөлийг бүрдүүлнэ. Мөн төслийн орчимд түймэр алдах, тээврийн хэрэгслээр хатуу хучилтаас гадуур зам гаргаснаас хөрс эвдрэх, ахуйн бохир ус, хатуу хог хаягдал хур борооны усаар угаагдаж хөрсөнд шингэх, шатах тослох материал, химийн бодис асгарах нь хөрс, усны бохирдол, ургамал бохирдуулах зэрэг ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болох нь харагдаж байна.



Хүснэгт 2 Төслийн гол сөрөг нөлөөлөл

Үйл ажиллагаа	Химийн бодисын гол сөрөг нөлөөлөл	
	Хүний эрүүл мэндэд	Байгаль орчинд
<b>Химийн бодисын хоруу чанараас</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Арьс, нүд хамар хоолойг цочроох</li> <li>- Залгивал хортой, урагт нөлөөлж болзошгүй</li> <li>- Удаан амьсгалбал амьсгалын замын эрхтэн системийг гэмтээж болзошгүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Усан орчинд нөлөөлөл үзүүлэх</li> <li>- Усны амьтдад нөлөөлөх</li> <li>- Усан орчны организмд удаан хугацаагаар нөлөөлнө.</li> </ul>
<b>Агуулахын үйл ажиллагаанаас</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Ажиллагсад химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны дүрэм журмын талаар мэдлэггүй, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлгүй ажиллах үед бодис асгарах, нүдэнд хүрэлцэн цочроох, хурц болон ужиг архаг хордлого зэрэг эрсдэл үүсэж болзошгүй</li> <li>- Төслийн үйл ажиллагааны явцад ажиллагсдын анхаарал болгоомжгүй үйл ажиллагааны улмаас бодис асгарах улмаар галын аюул үүсвэл шаталтын дунд хорт хий ялгаруулж байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.</li> <li>- Ажиллагсдын дотоод журмын зөрчил, ажлын хариуцлага алдах зэргээс дээрх эрсдэл үүсэж болзошгүй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын үеийн аюулгүй ажиллагаа алдагдах, осол аюулын улмаас химийн бодис уурших замаар агаар, хөрсний хими, физик шинж чанарыг өөрчлөх, бохирдуулах, орчинд тархах</li> <li>- Химийн бодисын сав баглаа боодол болон ахуйн хог хаягдлыг журмын дагуу зайлууулж, усгтаагүй, ил задгай хаях зэргээс байгаль орчинд бохирдол үүсэж болзошгүй.</li> <li>- Агаарт эвгүй үнэр тархаах болон хийн бохирдол үүсгэх</li> </ul>

Химийн бодисыг тээвэрлэх, хадгалах үеийн аюулгүй ажиллагааны дүрэм, журам, зааврыг баримтлан ажиллаагүй нөхцөлд санамсаргүй асгарч, алдагдсанаас агаар, ус, хөрсийг бохирдуулах, хатуу шингэн хаягдлын хэмжээг нэмэгдүүлэх, ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх зэргээр богино хугацаанд байгаль орчин болон ажиллагсдын эрүүл мэндэд шууд нөлөөлөх сөрөг нөлөөллийн эрчмийг нэмэгдүүлж болзошгүй.

### 3.2 Болзошгүй болон гол сөрөг нөлөөллийн үнэлгээний дүгнэлт

Мэргэжлийн байгууллагын зүгээс дараах дүгнэлтийг өгөв. Төсөл хэрэгжих үед байгаль орчин, хүн амд үзүүлэх болзошгүй нөлөөлөл, түүний дотроос химийн бодисоос нөлөөлөх гол сөрөг нөлөөллийг тодруулах зорилгоор химийн бодисын хор аюулын лавлагаа болон төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж тайланг нэгтгэв.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр химийн бодисоос гарч болох гол сөрөг нөлөөллүүдийг дараах байдлаар нэгтгэн урьдчилан тогтоолоо. Үүнд:

- Агуулахад хадгалах химийн бодисууд хоруу чанар амаар “Дунд зэргийн аюултай-2 бодис”, арьсаар “Дунд зэргийн аюултай-1 бодис”, амьсгалаар “Онцгой аюултай-5 бодис”, “Байгаль орчин-Усан орчинд онцгой аюултай-5 бодис тус тус байгаа нь хадгалах болон тариалалтад хэрэглэх үйл ажиллагааны явцад ажилчид хордох болон агуулахын орчны хөрс ус бохирдох эрсдэлтэй байна.
- Компанийн агуулах байр талбайн хүрэлцээ хангалттай байгаа нь химийн хорт аюултай бодисуудыг ангилан хадгалах боломж харагдаж байна. Энэ нь хадгалах явцад болзошгүй гэнэтийн осол гарах, бодисын хурц хордлогод ажилтан өртөх эрсдэл бага байхаар байна.
- Агуулахын орчин нөхцөлийн хувьд агааржуулалт хангалттай бус буюу механик агааржуулалт хэрэглэхээр төлөвлөсөн байгаа нь орчны агаарт химийн бодис шууд цацагдах эрсдэлтэй байна.

- Агуулахын битүүмжлэл муу, дотоод тохижилтод анхаарах шаардлагатай, галын аюулгүй байдлыг хангах шаардлагатай.
- Агуулахын дотоод цахилгааны монтаж галын аюулгүй байдал хангагдаагүй, агуулахын байр стандарт шаардлагад нийцсэн байдал муу байгаа нь цаашид аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй, учрах аюул ослын эрсдэл үүсэх нөхцөл өндөр байна.
- Байгаль орчин хамгаалах үүргийнхээ дагуу агуулахын болон ашиглах талбайн орчны тохижилтыг сайжруулах шаардлагатай.
- Агуулах байршиж байгаа хэсэг хүлэмжийн аж ахуйн хашаанд байрлаж байгаа нь орчны бохирдол, хүн амын өртөлтийн зэрэг нэмэгдэх хандлагатай байна. Тиймээс агуулахын талбайг тусгайлан хашаалах, харуул хамгаалалт /цоожтой хашаа/ бүхий байлгах, аюулын зурвас шуудуу татаж үерийн ус урсан орохоос сэргийлсэн ажилбаруудыг хийх шаардлагатай.
- Орчинд агаараар химийн бодисын уур, тоосонцор алдахгүй, хамгаалах зорилгоор агуулахын орчноос тодорхой зайд /250-300м/ тойруулан мод суулгах тарьж ургуулсан байх хэрэгтэй.

### 3.3 Сөрөг нөлөөллийг багасгах, арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагаатай холбогдох хууль, дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллахаас гадна химийн бодисын онцлог шинж чанар, хор аюул, хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт талаар ажиллагсад мэдлэг олгож, болзошгүй сөрөг нөлөөлөл, осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд авах арга хэмжээний талаар дотоод дүрэм, журам боловсруулан мөрдөж ажиллах нь зүйтэй.

Хүснэгт 3 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

№	Төслийн гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ
1.	Энгийн хог хаягдлаас үүдэлтэй орчны бохирдол үүсэх. Хог хаягдал ил задгай хаях, хог хаягдлын цэгт ариутгал халдваргүйтгэл хийхгүй байх, тогтмол хугацаанд зайлуулаагүйгээс элдэв шавж үржих, халдварт өвчний эх үүсгэвэр болох	<ul style="list-style-type: none"> <li>- Зориулалтын тусгай цэг тохижуулах</li> <li>- Тогтсон хугацааны давтамжтай, тогтмол ачин зайлуулах</li> <li>- Хогийн цэгт байнга ариутгал халдваргүйжүүлэлт хийх</li> <li>- Зориулалтын бус газарт шатааж агаар орчин бохирдуулахгүй байх</li> <li>- Ил задгай хаяж орчныг бохирдуулахгүй байх</li> </ul>
2.	Тээврийн хөдөлгөөн ихсэх, хөрс, ургамал талагдах	<ul style="list-style-type: none"> <li>- Орчны хөрсийг тогтмол цэвэрлэх, нөхөн сэргээх, зүлэгжүүлэх, мод тарих,</li> <li>- Тогтоосон замыг засаж сайжруулах, тэмдэглэгээ хийх, явган хүний зорчих замыг хийж тохижуулж, асфальтаар хучих зэрэг арга хэмжээ авах</li> </ul>
3.	Химийн бодисоор агаар ус, хөрс бохирдох	<ul style="list-style-type: none"> <li>- Агуулахын агааржуулалтын ажиллагааг байнга хянаж хэвийн ажиллагаатай байлгах, агааржуулалтын систем мембран шүүлтүүртэй байх,</li> <li>- Бодис хадгалах савыг битүүмжлэл сайтай байлгах</li> <li>- Хадгалах, тээвэрлэх, худалдаалах, ашиглах үеийн аюулгүй ажиллагааны заавар боловсруулан мөрдөж ажиллах</li> <li>- Агуулахыг хариуцсан мэргэжлийн хүн ажиллуулах</li> </ul>

№	Төслийн гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ
		<ul style="list-style-type: none"> <li>- Бодисын хор аюулын талаарх мэдээлэл, танилцуулах самбар тэмдэг тэмдэглэгээг агуулахад ил байршуулах</li> <li>- Химийн бодистой холбоотой сургалт семинар байнга зохион байгуулах</li> <li>- Гадаргын болон газрын доорх усанд алдахгүй байх</li> </ul>
4.	Химийн бодист өртөх, хүн амьтанд хортой аюултай нөлөө үзүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Химийн ШУ, химийн бодисын талаар суралцсан мэргэжлийн хүн ажиллуулах</li> <li>- Бодисын хор аюул, нөлөөллийн талаарх мэдээ мэдээлэл өгөх сургалт байнга зохион байгуулах</li> <li>- Байгальд ил задгай хаяхгүй байх</li> <li>- Бодистой ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр бүр өгөх</li> <li>- Зааварчилгаа, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих</li> <li>- Болзошгүй осол эрсдэлээс ямагт урьдчилан сэргийлж анхаарал болгоомжтой ажиллах, эрсдэл тохиолдсон үед хэрэглэх хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэл, гал унтраах багаж хэрэгслийг бэлэн байлгах.</li> </ul>
5.	Химийн бодисоор бохирдсон хортой, аюултай хог хаягдал гарах	<ul style="list-style-type: none"> <li>- Аюултай хог хаягдал үүсгэгчийн код авах</li> <li>- Хог хаягдлын тухай хуулийг мөрдөж ажиллах</li> <li>- Химийн бодисын сав баглаа боодлыг худалдан авагч нараасаа тоо ширхгээр нь буцаан татан авч түр хадгалах.</li> <li>- Аюултай хог хаягдал цуглуулж түр хадгалах тусгай цэг, хадгалах агуулах бий болгож хяналттай байлгах</li> <li>- Химийн бодисоор бохирдсон материал, эд зүйл, хугацаа дууссан бодис урвалж зэрэг аюултай хог хаягдлыг ангилан хадгалах</li> <li>- Бохирдсон бүх зүйлийг тусгайлсан хогийн цэгт түр хадгалах</li> <li>- Аюултай хог хаягдлыг хуульд заасны дагуу хэмжээнээс хамааран 90 хоног хүртэл хадгалах</li> <li>- Эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байгууллагатай эрх шилжүүлэх гэрээ хийх, аюултай хог хаягдал устгах тусгай зөвшөөрөлтэй компанид эрх шилжүүлэн хүлээлгэн өгөх.</li> <li>- Эрх шилжүүлэхдээ дагалдах бичиг баримтыг бүрдүүлж ажиллах</li> <li>- Аюултай хог хаягдлын тайланг жил бүрийн 11 сард гаргаж харъя дүүргийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст албан тоотоор хандан хүргүүлэх</li> <li>- Дээрх үйл ажиллагаануудын хууль эрх зүйн үндсийг доор тусгав. Үүнд:</li> <li>- <b>Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/</b></li> <li>- <b>Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам /2018, 116-р тогтоол 1 дүгээр хавсралт/</b></li> </ul>

## ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

### 4.1 Зорилго

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутагт дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.

### 4.2 Зорилт

- БООУ-гээр дүгнэгдсэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээнүүдийг шат дараатай авч ажиллах
- Нутгийн уугуул иргэдтэй нээлттэй харилцаж, байгаль орчинд халгүй нөхцөлийг бүрдүүлж хамтран ажиллах
- Мэдээллийн ил тод байдлыг хангаж, нутгийн иргэд болон засаг захиргааны нэгжүүдтэй нягт уялдаатай ажиллах зорилтуудыг тавьж ажиллана.

### 4.3 Хамрах хүрээ:

Манай төслийн хувьд хамрах хүрээгээ өөрийн төсөл хэрэгжих газар талбайд төдийгүй, харьяа нутаг дэвсгэрийн ус, хөрс, ан амьтан хамгаалах, үргэж зайлахаас сэргийлэн ажиллахаар төлөвлөж байна.

Хүснэгт 4 2024 оны төлөвлөсөн БОМТ-ний нэгтгэл мөнгөн дүн

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Тухайн жилийн зардал /мян.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,540.0
2	Нөхөн сэргээлт, зүлэгжүүлэх арга хэмжээ	475.0
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,250.0
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,600.0
7	Удирдлага зохион байгуулалт	500.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	545.0
Нийт		5,910.0



#### 4.4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 5 Сөрөг нөлөөлөл бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	5	6	7	8	9
1	Агаарын чанар	Агаарын бохирдол үүсгэхгүй байх үүднээс түүхий нүүрс түлэхгүй байх	Төслийн хүрээнд	-	-	-	Тухайн жилд	Агаарын тухай хууль, MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2		Агулахад орчны чийг дулаан хэмжигч байршуулах, орчны хэлбэлзэл байгаа эсэхэд хяналт тавих	Агуулахад					
3		Хогийн цэгийн ариутгал хийх	Төслийн талбайд	20.0	2	40.0	8-9 дүгээр саруудад, сард сар бүр	
4	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Төслийн хашаа доторх зам талбайд тоосжилт үүсэхээс сэргийлж явган хүний зам, авто машины зам, зогсоолыг хатуу хучилттай болгож тохижуулах.	Төслийн талбайд	-	-	-	Тухай бүр	Газар доорх усыг бохирдлоос хамгаалах: MNS3342:1982, Усны тухай хууль ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/
5		Ахуйн хог хаягдлын цэгийг хатуу хучилтаар хучих, хогийн сав ус орхооргүй битүүмжлэлтэй байж хөрсөнд бохир алдахгүй байхаар тохижуулах	Төслийн талбайд	-	-	-	9 сард	
6	Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг	Төслийн табайн унаган төрх алдагдаагүй хэсгийг хашаалах, хамгаалах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах.	Төслийн талбайд	1500.0	-	1500.0	9 сард	MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
7	Газрын хэвлий	-	-	-	-	-	-	-
<b>Нийт</b>						<b>1540.0</b>		

#### 4.5 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ

Хүснэгт 6 Нөхөн сэргээлтийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /ш/	Нэгжийн зардал, мян/төг	Нийт зардал, мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Нөхөн сэргээлт	“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”, Сэлэнгэ аймгийн байгаль орчны газрын чиглүүлэгээр эсвэл харьяа сумын захиргаатай зөвшилцөн заасан талбайд мод тарих	тухай бүр	78	3.5	275.0	10 дугаар сард	<i>MNS 5914-2008- Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт. MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага</i>
2		Төслийн талбай орчны тохижилт, цэвэрлэгээнд анхаарах, эзэмшил талбайн гаднах 50м радиуст цэвэрлэгээ хий, тэмдэг тэмдэглэгээг засах, сайжруулах	тухай бүр	2	100.0	200.0	Тухай бүр	
<b>Нийт</b>						<b>475.0</b>		

#### 4.6 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ

Тухайн төсөл хэрэгжих газар нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутаг дэвсгэрт байрлах ба төслийн чиглэл, хүчин чадал, үйл ажиллагаатай холбоотойгоор хүн амыг нүүлгэх шаардлагагүй юм.

#### 4.7 Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ

Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа явуулж буй тус газар нь суурин бүсэд байрладаг. Тухайн талбайд түүх соёлын дурсгалт зүйл илрээгүй бөгөөд төслийн хэрэгжилтийн үед түүх соёлын дурсгалт зүйл илэрсэн тохиолдолд харьяалах орон нутгийн байгаль орчны газар, соёлын өв хариуцан ажиллаж буй ажилтан албан байгууллагад хандан мэдэгдэх үүрэг хүлээнэ.

#### 4.8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ

Төсөл хэрэгжүүлэгч “Өгөөж оргил” ХХК нь “Ургамал хамгааллын бодис импортлох, хадгалах, худалдаалах” төслөөс үүсэж буй хог хаягдлаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бага хэмжээнд байлгахаар төлөвлөх нь зүйтэй бөгөөд хөрсийг бохирдуулахгүйн тулд хог хаягдлыг түр хадгалах цэгт ангилан битүүмжлэлтэй саванд байршуулах, энэ талаар зохих мэдлэгийг ажиллагсад өгч ажиллах нь зүйтэй юм.

Хүснэгт 7 Осол эрсдэлийн менежмент

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Түрээсээр ашиглаж байгаа тоног төхөөрөмжийн үзлэг оношлогоо хийлгэсэн эсэхэд хяналт тавих, аюулгүй байдлаа хангаж ажиллах	Төслийн хүрээнд	Тухай бүр	-	-	Тухай бүр	<i>Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай.</i>
2		Агуулахын дотор болон гадна гал унтраах багаж хэрэгсэл байрлуулах, сэрэмжлүүлэх тэмдэглэгээ, самбар зэргийг ил байршуулах	Агуулахад	1	750.0	750.0	1 удаа	
3		Ажилтныг хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хувцас, хамгаалах хэрэглэлээр хангаж ажиллах	Төслийн хүрээнд	Тухай бүр	500.0	500.0	Тухай бүр	
4		Ургамал хамгаалах бодисыг "Найруулах аргачилал; Аюулгүй ажиллагааны зааварчилгаа; Хор аюулын лавлах мэдээлэл зэргийг боловсруулан батлаж, бодис худалдаалахдаа дагалдуулан борлуулдаг байх;	Төслийн хүрээнд	Тухай бүр	-	-	Тухай бүр	
<b>Нийт</b>						<b>1250.0</b>		

Хүснэгт 8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Хог хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлыг гэрээний дагуу ачин зайлууулж байх	Төслийн хүрээнд	Гэрээний дагуу	160.0	10	1600.0	Улирал бүр	<i>Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль,</i>
2		Хог хаягдлыг ангилан ялгах, дахиврыг боловсруулах үйлдвэр, аж ахуй нэгжид нийлүүлэх, баримтжуулах	Төслийн хүрээнд	тухай бүр	-	-	-	тухай бүр	
3	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдал буюу худалдан борлуулж байгаа ургамал хамгаалах бодисын сав баглааг буцаан татан авах.	Төслийн хүрээнд	тухай бүр	-	-	ҮА зардлаар	тухай бүр	
4		Буцаан татан авсан сав баглаа боодлыг тусгай эхр бүхий байгууллагад өгч эрх шилжүүлэх, дагалдах баримт бичигийг бүрдүүлэх	Төслийн хүрээнд	тухай бүр	-	-	Тухайн гарсан кг жингээр үнэ тооцох	тухай бүр	
5		Бодисын сав баглааг импорт хийсэн тоо хэмжээтэй харьцуулан тооцоолж, ургамал хамгаалах бодисын болон сав баглаа боодлын тайлан гаргах.	Төслийн хүрээнд	Жилийн эцэст	-	-	ҮА зардлаар	тухай бүр	
<b>Нийт</b>							<b>1600.0</b>		

Хүснэгт 9 Удирдлага зохион байгуулалт ба осол эрсдэлийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Үүсэж болзошгүй гэнэтийн осол аваар, галын аюул, цахилгаан техникийн гэмтэл.	Гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Төслийн хэмжээнд	-	батлуулсан байх	Байгаль орчны тухай хууль
2		Компанийн удирдлагуудыг "ХАБЭА сургалт - компанийн удирдлагад чиглэсэн" сургалтад хамруулах.	Удирдлагууд	500	1 удаа	
<b>Нийт зардал /мян/төг/</b>				<b>500.0</b>		

#### 4.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөө

Хүснэгт 10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг /мян.төг/	Тайлбар	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
	1	2	3	4	5	6	7	8
<b>Агаарын чанар</b>								
1.1	Агаарын бохирдлын (NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , CO) шинжилгээ хийлгэж байх /БОТЛ мэргэжилтэн хөлслөн хийлгэнэ/	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 1-2 цэг сонгох.	Хагас жилд 1 удаа	1	35.0	70.0	-	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага,
1.2	Агаарын тоосны (TSP, PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> ) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх		Хагас жилд 1 удаа	1	35.0	70.0		MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
1.3	Дуу шуугиан, чичиргээ: үйлдвэрийн тоног төхөөрөмжийн орчим		Хагас жилд 1 удаа	1	35.0	70.0		MNS ISO 226:2003 Дуу чимээ-хэвийн норм, түвшиний хэмжээ
<b>Усны хяналт шинжилгээ</b>								
2.1	Унд ахуйн цэвэр усны шинжилгээ – /Хими, микробиологи, хүнд металл/	Цэвэр уснаас дээжлэх	Хагас жилд 1 удаа	1	95.0	190.0	-	MNS 6561:2015 Ариутгах татуургын хамжээнд нийлүүлэх хаягдал ус ТЕШ
<b>Хөрсний бохирдол</b>								
3.1	Хөрсний шинжилгээ – Агро хими	Хогийн цэг орчмоос 1, Төслийн талбайн зүүн хойд хэсгээс 1	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	45.0	45.0	-	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS 5850:2029 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3.2	Хөрсний шинжилгээ – Хүнд металл /6 үзүүлэлт/				85.0	85.0		
3.3	Хөрсний шинжилгээ – Механик бүрэлдэхүүн				15.0	15.0		
<b>Амьтны аймаг</b>								
4.1	Амьтны аймаг	-	-	-	-	-	-	
<b>ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 2024 ОНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>						<b>545.0</b>		



## ДҮГНЭЛТ

“Өгөөж оргил” ХХК нь “Ургамал хамгааллын бодис импортлох, хадгалах, худалдаалах” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны үнэлгээний зөвлөх байгууллага “Бурхан Буудай Бүтээмж” ХХК хийж гүйцэтгэлээ.

2024 оны төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд 475 000 төгрөг, осол эрсдэлийн төлөвлөгөөнд 1 250 000 төгрөг, хог хаягдлын төлөвлөгөөнд 1 600 000 төгрөг, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд 500 000 төгрөг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 545 000 төгрөг нийт **5 910 000** төгрөг зарцуулахаар төлөвлөж байна.

Төсөл хэрэгжүүлэгч “Өгөөж оргил” ХХК нь хуулийн хариуцлагын хүрээнд 2024 оны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах үүрэг хүлээж энэхүү төлөвлөгөөг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд (БОУАӨЯ) хүргүүлэв.

## Хавсралт материалын жагсаалт

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ

2. Газрын захирамж
3. Газрын гэрчилгээ, кадастр
4. Энгийн хог хаягдлын гэрээ
5. Тээврийн хэрэгсэлд халдваргүйтгэл хийх гэрээ
6. Кемпийн байранд ариутгал, халдваргүйтгэл хийх гэрээ
7. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, халдваргүйжүүлэх, устгах, аюулгүй болгох гэрээ
8. Ахуйн бохир соруулах, тээвэрлэх гэрээ